



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/372

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний 256 дугаар анги үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан цэргийн албан хаагчдын ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор цэргийн байрны дээврийн засварын зардалд 31,716,800 (гучин нэгэн сая долоон зуун арван зургаан мянга найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100791